



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 1/595

Номгон

"Орос хэл, соёлын бүсийн баяр" арга  
хэмжээ зохион байгуулахад хөрөнгө  
зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол улсын Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20 - ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь

1.Оросын холбооны улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яамны зөвлөх, Россотрудничество агентлагийн Монгол улс дахь төлөөлөгчийн газрын тэргүүн, "Русский Дом в Улан -Баторе"-ийн захирлын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн Рз73-54/1 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Говь-Алтай, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай аймгийн оролцогч нарын Баянхонгор сумд байх хугацааны байрны зардлыг хавсралтаар баталсугай.

2."Орос хэл, соёлын бүсийн баяр"-ыг зохион байгуулалтын өндөр түвшинд зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Алтанцэцэгт үүрэг болгосугай.

3.Бүсийн арга хэмжээнд оролцогчдын буудлын хөлс болох 5.208.000 (Таван сая хоёр зуун найман мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-т даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

624211509

Аймгийн Засаг даргын *Д.О.О* оны *10* дугаар сарын  
*20* ны өдрийн *2/6.25* дугаар захирамжийн  
хавсралт

"ОРОС ХЭЛ, СОЁЛЫН БҮСИЙН БАЯР"-Т  
ОРОЛЦОГЧДЫН БАЙРНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр төрөл	Хэмжих нэгж	Оролцох хүний тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ /
1	2	3	4	5	6
1	Орос хэл, соёлын баярт оролцогчдын байрны зардал	Хүн/хоног	28*3 хоног	62000	5.208.000
	Бүгд	/Таван сая хоёр зуун найман мянган төгрөг			5.208.000

оОо